



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар A/147

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит II хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 12 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тосонцэнгэл сумын 5 дугаар багийн иргэн Бат-Эрдэнэ овогтой Батбаатарын амьдарч байсан байшин нь шатаж, 90.5 сая төгрөгийн гарз хохирол учирсан тул амьдрах орон байртай болоход нь зориулж 2,000,000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэг, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах хангайн бүсийн сургалт”-ын зардалд 3,157,600 (Гурван сая, нэг зуун тавин долоон мянга зургаан зуу) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын нийт 5,157,600 (Таван сая, нэг зуун тавин долоон мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

